

**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОНӨААТҮГ-ЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН
ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Биелэлт	Дүнд эзлэх хувь
1	4.1. Газрын зорилго нь нийслэлийн иргэд, зорчигчдын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх чанар, үр дүнг дээшлүүлэх, иргэдэд шуурхай боловсон ая тухтай үйлчлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлвийг тодорхойлох замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэхэд оршино.	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний 13 чиглэлд ажлын өдөр 94, амралтын өдөр 85 автобусаар тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж, техникийн бэлэн байдлын коэффициентийг 98.6 хувьтай ажиллаж байна. Сургуулийн хүүхэд зөөвөрлөх зориулалтын 8 автобусаар өдөр тутамд 7 сургуулийн 950 гаруй сурагчдад аюулгүй ажиллагааг хангуулан үйлчилгээ үзүүлж байна.	100.0%
2	4.2. Нийслэл Улаанбаатар хотод нийтийн тээврийн үйлчилгээг эрх бүхий байгууллагаас тогтоосон чиглэлийн замнал, хөдөлгөөний цагийн хуваарийн дагуу үзүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын удирдлага зохион байгуулна.	Ү:31, Ч:79 чиглэлүүдийн эцсийн зогсоолын нөхцөл байдлын талаар дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах хүсэлтийг Нийтийн тээврийн бодлогын газарт 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/05/142 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан. Мөн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Х:7 чиглэлийн автобусны зогсоолын нэршил, координатыг судлан зургийг хавсарган судалгааг хүргүүлэн зөрүүтэй тэмдэглэгдсэн зогсоолуудыг засварлуулсан. Х:6 Чиглэлийн судалгааг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр стандарт хангахгүй эцсийн автобусны зогсоолыг зургаар баримтжуулан саналыг Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн.	100.0%
3 4	4.3. Газар нь дараах үйл ажиллагааны үндсэн чиглэл, нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёсзүйн хэм, хэмжээ, хууль, тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах болно. Үүнд: 4.3.1. Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн хэрэгслээр хүргэх.	MNS 4601:2011 MNS 5012:2021 стандартад заасан ангилалын дагуу хуваарь гарган засвар үйлчилгээний ажлыг тогтмол гүйцэтгэж, техникийн бэлэн байдлын коэффициент 98.6 хувьтай ажилласан.	100.0%

10	4.6. Газар нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг дэлхийн ижил төстэй хотуудын түвшинд хүргэх, үйлчилгээний стандарт, тээвэрлэлтийн норм дүрэм, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах үүргийг хүлээнэ.	Нийтийн тээврийн автобусанд чанарын шаардлага хангасан дизель болон цэнхэр түлшийг нийлүүлэх 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр тендер сонгон шалгаруулалт зарлаж 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Т/110 дугаартай гэрээ байгуулж үйлчилгээний 95, сургуулийн хүүхэд зөөвөрлөх 8 автобуснаас ялгарах утаа, угаарыг бууруулан үйлчилгээний стандарт, тээвэрлэлтийн норм дүрэм, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллаж байна.	
11	4.7. Нийслэлийн Засаг даргад үйлчилгээний, үнэ хөлс тарифыг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон танилцуулга, мэдээлэл, санал хүргүүлнэ.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны №25/14 дүгээр тогтоолыг батлуулан нийтийн тээврийн үйлчилгээний, үнэ тарифыг мөрдүүлэн ажиллаж байна.	100.0%
12	4.8. Үйлдвэрийн газар нь үйлдвэрлэлийн болон нийтийн тээврийн үйлчилгээний материаллаг баазыг өргөтгөх, орчин үеийн тэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлэх, хүчин чадлыг нь бүрэн ашигласан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулна.	Тус байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор жолооч нарыг 6 хэсэгт хуваан Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/42 тушаалаар батлагдсан “Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тооцох аргачлал”-ыг жолооч нарт танилцуулан ашиглалттай холбоотой зөрчлүүдийг эрс бууруулж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн, мөн автобусны автомат угаалгын хэсэг, засвар үйлчилгээний төвийг ашиглалтад оруулан орчин үеийн тэвшилтэт шинэ техник технологийг нэвтрүүлэн ажиллаж байна.	100.0%
13	4.9. Газар нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, нийслэлийн Засаг Даргын гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг зохион байгуулна.	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Тээврийн хэрэгсэл балансаас баланст шилжүүлэх тухай” №А/274 дугаар захирамжийн хүрээнд эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2,759,832,000 (Хоёр тэрбум долоон зуун тавин есөн сая найман зуун гучин хоёр мянга) төгрөгийн бүртгэл бүхий БНХАУ-ын “Yutong Bus” компанид үйлдвэрлэгдсэн Yutong ZK6116HG загварын 10 ширхэг их багтаамжийн автобусыг	100.0%

Нийтийн тээврийн бодлогын газарт балансаас
балансад 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн
А/09 тоот тушаалаар шилжүүлсэн.

Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 05 дугаар сарын
01-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” №А/602 дугаар
захирамжийн хүрээнд нийтийн тээврийн автопаркийн
барилга (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)-ын ажлын
дуусгал нэртэй, 5,318.1 (Таван тэрбум гурван зуун
арван найман сая нэг зуун мянга) төсөвт өртөг бүхий
ажлыг tender.gov.mn цахим системд 2025 оны 05
дугаар сарын 30-ны өдөр нийтэлж төрийн болон орон
нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ
худалдан авах тухай хуулийн дагуу дагуу 06 дугаар
сарын 30-ны өдрийн 09:10 цагт тендерийн нээлтийг
зохион байгуулж, нийслэлийн Засаг Даргын Тамгын
газар, “Хайрхан уулын зам” ХХК болон “Сант өндөр”
ХХК-иудын түншлэлтэй 07 дугаар сарын 30-ны өдөр
гэрээ байгуулж гадна зам талбайн хашлага,
тэгшилгээ, суурийн бэлтгэл үе шатны ажлуудыг хийж
дуусгасан.

---000---

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Н.ДААРИЙМАА

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭЙН

Ц.ТОГТОХБУЯН